



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д дор дурдсан агуулгатай 2.4 дэх хэсэгт 2.4.1, 2.4.2, 2.4.3 дахь заалт, 2.5 дахь хэсгийг тус тус нэмсүгэй.

1/ “2.4.1 Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцахын эрсдэлийн хувь хэмжээг Стандарт энд Пурс (Standard & Poors), Мууди (Moody’s), Фич (Fitch) зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон рейтингийг ашиглан дараах хүснэгтийг үндэслэн тооцно.”;

Стандарт энд Пурс	AAA/AA-	A+/A-	BBB+/BBB-	BB+/B-	B-бага	Рейтинггүй банк
Фич						
Мууди	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B-бага	
Урт хугацаат авлага (3 сараас дээш)	20%	50%	50%	100%	150%	100%
Богино хугацаат авлага (3 сараас доош)	20%	20%	20%	50%	150%	100%

2/ “2.4.2 Гадаад валютын ханшийн эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлыг тооцохдоо гадаад валютын нээлттэй позицгийн дүнг нэмнэ.”;

3/ “2.4.3 Үйл ажиллагааны эрсдэлээс учирч болзошгүй хохирлоос сэргийлэхийн тулд ББСБ нь сүүлийн 3 жилийн татварын өмнөх эерэг ашгийн дунджийн 15 хувийг тухайн ББСБ-д мөрдөж байгаа өөрийн хөрөнгийн шаардлагын урвуугаар үржүүлэн нэмнэ.”;

4/ “2.5. Зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын хувьд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохгүй.”.

000006

2. Мөн журмын 2.1.3 дахь заалт, 2.4, 3.2, 3.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ “2.1.3. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, тэнцлийн активууд болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа бусдын өмнө хүлээж болзошгүй үүргүүдийн зохистой харьцаа 10 хувиас доошгүй байна. (цаашид "НАХ" гэх);”;

2/ “2.4. Эрсдэлээр жигнэсэн нийт активын дүнг тооцохдоо тэнцлийн активууд болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа бусдын өмнө хүлээж болзошгүй үүргүүдийн дүнг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан эрсдэлийн хувь хэмжээгээр үржүүлж, гарах нийлбэр дүнг дараах байдлаар тохируулна.”;

3/ “3.2. Түргэн борлогдох активыг касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцах дансны үлдэгдэл, Засгийн газар болон Төв банкны үнэт цаасны дүнгийн нийлбэрээр тооцно.”;

4/ “3.3. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг банк, санхүүгийн байгууллага, төслийн санхүүжилтээр авсан зээл, зээлийн хүүгийн өглөг, итгэлцлийн, факторингийн болон мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцооны үйлчилгээгээр үүссэн өглөг, ББСБ-аас гаргасан хаалттай өрийн бичиг, бусад пассив дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.”.

3. Мөн журмын 3.4 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

4. Нэмэлт, өөрчлөлтийг журамд тусгаж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/, журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2015 оны 3 дугаар улирлаас бүрэн хангаж ажилласан байхыг банк бус санхүүгийн байгууллагын ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА